

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/177/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам
Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.27 № 01/239
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
И.ӨЛЗИЙБАДРАХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түнэл сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлж байна.

Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 71,774.8 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь эм 21,523.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 36,467.2 мянган төгрөг нийт 57,990.2 мянган төгрөгийн тендергүй худалдан авалт хийсэн ба аудитын хугацаанд 2 алдаа залруулж, албан шаардлага өгөөгүй, 1 төлбөрийн акт тогтоож, дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 3 зорилтын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 94.6 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын

стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 33/АБЭБӨНЗБ/ХАА-2022/177
/НА-СТА-ТМЗ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Байгууллагын төсвөөс 2,531,000 (Хоёр сая таван зуун гучин нэгэн мянган) төгрөгийн гар утасны нэгж худалдан авч эмнэлгийн ажилтнуудад олгосон байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 “гар утасны зардал” гаргахыг хориглоно гэсэн заалттай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Байгууллагын төсвөөс үр ашиггүй зардал гаргаж Эмнэлгийн ажилтнуудад гар утасны нэгж худалдан авсан 2,531,000 /хоёр сая таван зуун гучин нэгэн мянга/ төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн дарга И.Өлзийбадрах, нягтлан бодогч Н.Гэрэлтуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>234,865,815.79</u>	<u>317,218,404.77</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,755,050.00	71,774,798.65
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,755,050.00	71,774,798.65
31211	Төрийн сангийн харилцах	19,755,050.00	71,774,798.65
33	АВЛАГА	42,902,402.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	42,323,200.00	00.00
335	Бусад авлага	579,202.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	579,202.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	172,208,363.79	245,443,606.12
351	Түүхий эд материал	89,901,874.79	113,859,598.52
35110	Тусгай зориулалттай материал	6,325,251.00	00.00
35130	Эм боох материал	83,576,623.79	113,859,598.52
354	Хангамжийн материал	80,295,809.00	131,584,007.60
35410	Бичиг хэргийн материал	1,243,131.00	5,781,950.10
35420	Аж ахуйн материал	51,357,750.00	68,885,550.00
35460	Хүнсний материал	7,579,288.00	18,994,287.50
35470	Бусад хангамжийн материал	20,115,640.00	37,922,220.00
35600	Мал амьтад	2,010,680.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,359,607,971.70</u>	<u>1,410,654,904.36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,359,607,971.70	1,410,654,904.36
392	Биет хөрөнгө	1,341,487,971.70	1,392,693,304.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,327,071,414.00	1,327,071,414.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-113,623,213.20	-136,847,973.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,989,219.00	61,460,556.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-13,510,312.58	-12,903,690.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	102,388,656.00	173,163,127.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17,995,290.58	-36,549,559.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,585,300.00	33,510,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,417,800.94	-16,210,869.38
393	Биет бус хөрөнгө	18,120,000.00	17,961,600.00
39301	Програм хангамж	792,000.00	792,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-158,400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,328,000.00	17,328,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,594,473,787.49</u>	<u>1,727,873,309.13</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,594,473,787.49	1,727,873,309.13
51	Засгийн газрын хувь оролцоо	1,594,473,787.49	1,727,873,309.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	148,642,601.00	148,642,601.00
51101	Өмч: - төрийн	148,642,601.00	148,642,601.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,425,635,493.35	1,559,035,014.99
51210	Өмнөх үеийн үр дүн	1,425,635,493.35	1,425,635,493.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	133,399,521.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,195,693.14	20,195,693.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,594,473,787.49</u>	<u>1,727,873,309.13</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	924,348,132.45	821,456,194.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	265,879,797.45	139,114,654.97
120	Нийтлэг татварын бус орлого	265,879,797.45	139,114,654.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,833,509.00	81,710,027.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	579,202.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	231,472,135.00	682,341,540.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	426,996,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	157,238,230.00	1,019,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	113,250.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,801,780.00	1,019,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,683,300.00	41,683,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,683,300.00	41,683,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	34,550,605.00	639,639,240.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,550,605.00	639,639,240.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	592,515,254.11	686,725,779.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	592,515,254.11	686,725,779.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	590,329,019.11	686,204,404.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359,363,501.00	379,501,268.35
210101	Үндсэн цалин	325,628,059.00	239,531,606.74
210102	Нэмэгдэл	9,964,036.00	97,906,248.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,856,000.00
210104	Урамшуулал	23,771,406.00	34,828,147.90
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,379,265.65
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,216,348.00	47,705,651.00
210201	Тэтгэврийн даатгал	32,785,918.00	34,103,772.41
210202	Тэтгэмжийн даатгал	4,950,872.00	3,393,389.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,614,964.00	2,704,551.53
210204	Ажилгүйдлийн даатгал	617,592.00	664,216.68
210205	Эрүүл мэндийн даатгал	6,247,002.00	6,839,720.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,183,300.00	35,661,925.00
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,478,625.00
210302	Түлш, халаалт	31,903,000.00	31,903,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,280,300.00	1,280,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,676,424.00	41,144,981.90
210401	Бичиг хэрэг	3,153,134.00	1,963,330.90
210402	Тээвэр, шатахуун	19,587,330.00	21,691,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,130,000.00	5,341,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,837,420.00	2,916,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,427,640.00	7,222,311.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	540,900.00	2,010,680.00

Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	60,972,273.47	95,795,713.74
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,855,600.97	86,285,313.24
210502	Хоол, хүнс	11,116,672.50	9,510,400.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,964,603.76	18,272,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	12,420,000.00
210604	Урсгал засвар	3,964,603.76	5,852,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,243,000.00	1,766,000.00
210702	Дотоод албан томилолт	1,243,000.00	1,766,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,161,727.00	3,051,564.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	2,028,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,500.00	139,510.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,010.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	42,217.00	30,154.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,547,841.88	63,304,800.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,439,520.00	10,222,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,108,321.88	53,082,200.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,186,235.00	521,375.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,186,235.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,186,235.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	521,375.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	521,375.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>331,832,878.34</u>	<u>134,730,415.89</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	196,295,706.60	1,330,894.25
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,073,333.38	1,330,894.25
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-196,295,706.60	-1,330,894.25
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>135,537,171.74</u>	<u>133,399,521.64</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>616,145,135.00</u>	<u>724,664,740.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	42,323,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	42,323,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	42,323,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	42,323,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	616,145,135.00	682,341,540.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	426,996,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,915,030.00	1,019,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,683,300.00	41,683,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,683,300.00	41,683,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	34,550,605.00	639,639,240.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,550,605.00	639,639,240.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>598,576,320.00</u>	<u>648,894,991.35</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	598,576,320.00	648,894,991.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	596,390,085.00	648,373,616.35

Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359,363,501.00	379,501,268.35
210101	Үндсэн цалин	212,139,538.00	239,531,606.74
210102	Нэмэгдэл	102,508,214.00	97,906,248.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,856,000.00
210104	Урамшуулал	41,161,049.00	34,828,147.90
210105	Гэрээт ажлын хөлс	3,554,700.00	3,379,265.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,216,348.00	47,126,449.00
210201	Тэтгэврийн даатгал	33,880,612.47	33,851,085.67
210202	Тэтгэмжийн даатгал	3,562,255.39	3,393,389.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,795,587.28	2,704,551.53
210204	Ажилгүйдлийн даатгал	717,494.02	664,216.68
210205	Эрүүл мэндийн даатгал	6,260,398.84	6,513,205.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,183,300.00	35,661,925.00
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,478,625.00
210302	Түлш, халаалт	31,903,000.00	31,903,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,280,300.00	1,280,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,269,080.00	50,828,450.00
210401	Бичиг хэрэг	2,820,000.00	3,086,050.00
210402	Тээвэр, шатахуун	17,552,430.00	21,691,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,130,000.00	5,341,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,327,650.00	11,574,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,439,000.00	9,136,000.00
2105	Нормативт зардал	77,984,879.00	88,582,460.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,540,269.00	60,073,560.00
210502	Хоол, хүнс	13,144,610.00	20,925,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,300,000.00	7,583,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,688,000.00	22,926,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,640,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	11,866,300.00
210604	Урсгал засвар	5,048,000.00	11,060,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,243,000.00	1,766,000.00
210702	Дотоод албан томилолт	1,243,000.00	1,766,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,161,727.00	11,757,664.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	6,998,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,040,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,500.00	139,510.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,010.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	42,217.00	30,154.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	3,416,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,280,250.00	10,222,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,280,250.00	10,222,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,186,235.00	521,375.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,186,235.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,186,235.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	521,375.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	521,375.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>17,568,815.00</u>	<u>75,769,748.65</u>

Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	23,750,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	23,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	23,750,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-23,750,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,568,815.00	52,019,748.65
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	19,755,050.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,568,815.00	71,774,798.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,642,601.00	25,078,291.74	1,276,887,843.18	1,450,608,735.92
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,642,601.00	25,078,291.74	1,276,887,843.18	1,450,608,735.92
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,120,335.61	9,120,335.61
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,642,601.00	20,195,693.14	1,425,635,493.35	1,594,473,787.49
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,642,601.00	20,195,693.14	1,425,635,493.35	1,594,473,787.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,642,601.00	20,195,693.14	1,425,635,493.35	1,594,473,787.49
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	133,399,521.64	133,399,521.64
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,642,601.00	20,195,693.14	1,559,035,014.99	1,727,873,309.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		19,755,050.00	(19,755,050.00)	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	737.314.800.00	672,644,991.35	64,669,808.6	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	737.314.800.00	672,644,991.35	64,669,808.6	91.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	737.314.800.00	672,644,991.35	64,669,808.6	91.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	390.675.000.00	379.501.268.35	11,173,731.65	97.1
210101	Үндсэн цалин	198.363.200.00	239.531.606.74	(41,168,406.74)	120.8
210102	Нэмэгдэл	145.209.900.00	97.906.248.06	47,303,651.94	67.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4.200.00000	3.856.000.00	344,000.00	91.8
210104	Урамшуулал	39.050,000.00	34.828.147.90	4,221,852.10	89.2
210105	Гэрээт ажлын хөлс	3.851.900.00	3.379.265.65	472,634.35	87.7

Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48.834.200.00	47.126.449.00	1,707,751.00	96.5
210201	Тэтгэврийн даатгал	33.207.300.00	33.851.085.67	(643,785.67)	101.9
210202	Тэтгэмжийн даатгал	3.906,700.00	3,393.896.46	513,310.54	86.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3.125.400.00	2.704.551.53	420,848.47	86.5
210204	Ажилгүйдлийн даатгал	781.300.00	664.216.68	117,083.32	85.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7.813.500.00	6,513.205.66	1,300,294.34	83.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36.183.300.00	35.661.925.00	521,375.00	98.6
210301	Гэрэл, цахилгаан	3.000.000.00	2.478.625.00	521,375.00	82.6
210302	Түлш, халаалт	31.903.000.00	31.903.000.00		100.0
210303	Цэвэр, бохир ус	1.280.300.00	1.280.300.00		100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	57.278.900.00	50.828.450.00	6,450,450.00	88.7
210401	Бичиг хэрэг	5,089.000.00	3.086.050.00	2,002,950.00	60.6
210402	Тээвэр, шатахуун	21.691.100.00	21.691.100.00		100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5.341.000.00	5.341.000.00		100.0
210404	Ном, хэвлэл	0	0		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11.574.300.00	11.574.300.00		100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13.583.500.00	9.136.000.00	4,447,500.00	67.3
2105	Нормативт зардал	117.258.800.00	88.582.460.00	28,676,340.00	75.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	86.021.700.00	60.073.560.00	25,948,140.00	69.8
210502	Хоол, хүнс	23.653.600.00	20.925.400.00	2,728,200.00	88.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7.583.500.00	7.583.500.00		100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61.833.500.00	46.676.800.00	15,156,700.00	75.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	36.467,200.00	23.750.000.00	12,717,200.00	65.1
210602	Тавилга	0	0		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,866.300.00	11.866.300.00		100.0
210604	Урсгал засвар	13.500,000.00	11.060.500.00	2,439,500.00	81.9
2107	Томилолт, зочны зардал	2,095,000.00	1,766.000.00	329,000.00	84.3
210702	Дотоод албан томилолт	2,095.000.00	1,766.000.00	329,000.00	84.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,933.500.00	11.757.664.00	1,175,836.00	90.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6998.900.00	6.998.900.00		100.0

Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,716.500.00	1040000	676,500.00	60.6
210803	Даатгалын үйлчилгээ	425000	139.510.00	285,490.00	32.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141.500.00	100.000.00	41,500.00	70.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	126.500.00	33000	93,500.00	26.1
210807	Газрын төлбөр	109000	30.154.00	78,846.00	27.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3.416.100.00	3.416.100.00		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10.222.600.00	10.222.600.00		100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,222,600	10,222,600		100.0
	Төвлөрүүлэх шилжүүлэг		521375		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	737.314.800.00	724.664.740.00	12,650,060.00	98.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41.683.300.00	41.683.300.00		100.0
132001	Орон нутгийн төсвөөс	41.683.300.00	41.683.300.00		100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	695,631,500.00	639,639,240.00	55,992,260.00	92.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	695,631,500.00	639,639,240.00	55,992,260.00	92.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	42.323.200.00	(42,323,200.00)	
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	42.323.200.00	(42,323,200.00)	
	Дээд шатны төсөв захирагчаас		1,019,000.00	(1,019,000.00)	
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0	0		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	19,755,050.00	(19,755,050.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	71,774,798.65	(71,774,798.65)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0	0		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24		100
620001	Удирдах ажилтан	1	1		100
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19		100
620003	Үйлчлэх ажилтан	4	4		100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн тайлан байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Түнэл Эрүүл мэндийн төв нь Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг эрхэмлэн дээдэлж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ мэргэжлийн түвшинд хүртээмжтэй хүргэж, иргэн бүрд эрүүл зан үйлийг төлөвшүүлэн эрүүл аж төрөх дадлыг олгоно.

Түнэл сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн болон эрүүл мэндийн тусламжийн чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Хүний нөөцийн чадавхыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх
- Өрх, иргэн төрийн ба төрийн бус байгууллагын ажилтан албан хаагч бүрд эрүүл мэндийн боловсрол олгож, зөв дадал хэвшилд сургах, хамтран ажиллах
- Иргэдэд ээлтэй орчин бүрдүүлж, сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлэх
- Эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүйг эрхэмлэн ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан¹ 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан² тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд :

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам¹-ийн дагуу Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн

¹ “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

² “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

даргын 2022 оны 4 сарын 15-ны өдрийн А/14 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд 4 зүйл 23 бүхий ажлын төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Түнэл сумын Эрүүл мэндийн төв нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133,399.6 мянган төгрөгөөр буюу 8,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,755.0	71,774.8	52,019.8
Авлага	42,902.4	0	-42,902.4
Бараа материал	172,208.3	245,443.6	73,235.3
Үндсэн хөрөнгө	1,359,607.9	1,410,654.9	51,047.0
Нийт хөрөнгө	1,594,473.7	1,727,873.3	133,399.6
Өр төлбөр	0		
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,594,473.7	1,727,873.3	133,399.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,594,473.7	1,727,873.3	133,399.6

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, авлагын данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 52,019,8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 73,235,3 мянган төгрөгөөр өссөн нь хэвтэн эмчлүүлэгчдийн хоол, корона вирусийн үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 51,047,0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 105,460,0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба төсвийн хөрөнгөөр 27,253.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч 78,206.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 695,632,5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 41,683,3 мянган төгрөг үйл ажиллагааны орлогоос 42,323,2 мянган төгрөг нийт зарлагыг 737,314,8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг орон нутгийн санхүүжилт дээр 41,683.3 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 41,683.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 682,981.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас орлого бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 639,639,2 мянган төгрөг орон нутгийн төсвөөс 41,683.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 42,323.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,019.0 мянган төгрөг нийт 724,664.7 санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 672,123.6 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	371,206.2	353,826.7	17,379.5	95,3
2	Үндсэн тусламж үйлчилгээ	256,538.1	212,846.8	43,691.3	82,9
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	67,887.2	64,288.2	3,599.0	94.7
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	41,683.3	41,161.9	521.7	98,7
	Дүн	737,314.8	672,123.6	65,182.5	91,2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 53,195.6 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, Аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 592,515.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,850.3 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй зүйл илэрлээ.

Үүнд: Түнэл сумын ЭМТ-ийн даргын 2022.12.20-ны Б/42 тоот тушаалаар эмнэлгийн ажилтан албан хаагчдад 2,531.0 мянган төгрөгийн утасны нэгж авч өгч шуудан холбооны зардалд бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл.Бусад хангамж 12.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.1.гар утасны зардал; дэх заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 55,409.2 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 12,649.15 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 6.4.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл худалдан авалт 42,334.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ нийт 110,392.3 мянган төгрөгийн 6 гүйлгээг тус тус мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3. 6.4.5 дах заалтуудыг зөрчсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж хүргүүлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй болно

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага өгөөгүй, эмнэлгийн нэрийг шинэчлэх бүртгүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй гэсэн 2 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 85 хувьтай шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл дутуу оруулсан байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	19,100.0	2	19,100.0	85.0
Нийт дүн	2	19,100.0	2	19,100.0	85.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь эм 21,523.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 36,467.2 мянган төгрөг нийт 57,990.2 мянган төгрөгийн тендергүй худалдан авалт хийсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 179,253.8 мянган төгрөгийн алдаа³ илэрснээс аудитын явцад 29,453.8 мянган төгрөгийн алдааг залруулж, төлбөрийн акт 2,531.0 мянган төгрөг, 147,269.0 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн Нийт цэвэр мөнгөн гүйлгээ нь 19,755.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 9,698.8 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

Аудитаар нийт 149,800.0 мянган төгрөгийн зөрчил⁴ илэрснээс, төлбөрийн акт 2,531.0 мянган төгрөг, 147,269.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Түнэл сумын ЭМТ-ийн даргын 2022.12.20-ны Б/42 тоот тушаалаар эмнэлгийн ажилтан албан хаагчдад 2,531.0 мянган төгрөгийн утасны нэгж авч өгч шуудан холбооны зардалд бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл.Бусад хангамж 12.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.1.гар утасны зардал; дэх заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн эрүүл мэндийн зардлаас 5,657.3 мянган төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Энэ нь гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцээгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

2.Ой тэмдэглэсэнтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2022.08.16-ны өдрийн А/35 дугаартай Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар 70 жилийн ойг тэмдэглэн ХААН банкинд тусгай данс нээж 27,350.0 мянган төгрөгийн хандив бүрдүүлж зарцуулсан байна. Үүнд: хоол хүнсэнд 5,513.2 мянган төгрөг, бэлэг дурсгалд 6,843.2 мянган төгрөг, уралдаан тэмцээнд 3,800.0 мянган төгрөг, шатахууны зардалд 1,961.5 мянган төгрөг, хөрөнгө бэлтгэсэн 3,834.9 мянган төгрөг, материалын зардалд 5,397.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан нь төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5.хариуцлагатай байх. 41 дүгээр зүйлийн 41.2.2 батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, арилжааны банкинд Монгол банкны зөвшөөрлийн дагуу данс нээлгэх ба хандив тусламж авахгүй байх.

3.Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жилийн эцсийн тооллогын дүн 3,869.4 мянган төгрөг зөрүүтэй, тооцоо бодоогүй, тооллогын баримт дутуу нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцээгүй ба “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жил бүрийн эд хөрөнгийн тооллогыг цаглаварт заасан хугацаанд тогтмол хийж үр дүнг тооцож ажиллах

4.Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 55,409.2 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 12,649.15 мянган төгрөгийн 2 гүйлгээ, 6.4.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл худалдан авалт 42,334.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ нийт 110,392.3 мянган төгрөгийн 6 гүйлгээг тус тус мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3. 6.4.5 дах заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг буруу тайлагнасан	1	19,755.0			1	19,755.0	1	19,755.0				
Зардал хооронд гүйлгэн зарцуулсан	1	9,698.8			1	9,698.8	1	9,698.8				
Дүн	2	29,453.8			2	29,453.8	2	29,453.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	2	8,188.3	1	2,531.0			1	5,657.3				
Төсвийн гадуурх данс нээлгэсэн	1	27,350.0					1	27,350.0				
Хөрөнгийн тооллого зөрүүтэй	1	3,869.4					1	3,869.4				
Дүн	4	39,407.7	1	2,531.0			3	36,876.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ зөрүүтэй мэдээлсэн	1	110,392.3					1	110,392.3
Дүн	1	110,392.3					1	110,392.3

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ХААН СОЁМБО
АУДИТ
ХХК

ЗАХИРАЛ

Х.ДИЙМАА ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

02/21